

# “ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Ерөнхий боловсролын Нутгийн аваргууд ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2026/101/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Хөвсгөл аймаг  
2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Л.Мандахнаран  
Утас: 99389927 Цахим хаяг:  
[mandakhnaranl@audit.gov.mn](mailto:mandakhnaranl@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Ахлах аудитор: Г.Заяа  
Утас: 95648028, 98828028  
Цахим хаяг: [zaya96884510@gmail.com](mailto:zaya96884510@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.13 № 01/64  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН  
НУТГИЙН АВАРГУУД ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ М.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөрөн сумын Нутгийн аваргууд ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөрөн сумын Нутгийн аваргууд ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд улсын төсвөөс санхүүжих дүнг 48,018.7 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 155,198.4 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэн байна. Мөрөн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, хандив тусламж, 2023-2025 оны төсвийн хэмнэлт зэргээр бөхийн заалны барилгыг барин, аймгийн Орон нутгийн өмчийн даргын шийдвэрээр 211,511.0 мянган төгрөгөөр үнэлж данс бүртгэлд тусгажээ.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар хөрөнгийн худалдан авалт, дотоод хяналттай холбоотой 4,450.0 мянган төгрөгийн зөрчил илэрч холбогдох шийдвэрийг гаргасан болно.

**Бусад асуудлын хэсэг**

Мөрөн сумын Нутгийн аваргууд ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 30 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 85.4 хувьтай тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан*

*/төгрөгөөр/*

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тод	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	руулга		
<b><u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u></b>	<b>4</b>	<b>486,984,507.09</b>	<b>535,003,281.65</b>
төгрөг		486,984,507.09	535,003,281.65
Төрийн сангийн харилцах		486,984,507.09	535,003,281.65
<b><u>БАРАА МАТЕРИАЛ</u></b>	<b>6</b>	<b>74,864,804.82</b>	<b>88,054,958.22</b>
Түүхий эд материал		931,211.60	1,059,211.60
Эм боох материал		931,211.60	1,059,211.60
Хангамжийн материал		73,933,593.22	86,995,746.62
Бичиг хэргийн материал		2,587,000.00	2,411,300.00
Аж ахуйн материал		30,675,585.00	38,050,885.00
Сэлбэг хэрэгсэл		2,244,000.00	2,244,000.00
Түлш шатах тослох материал		-	40,000.00
Барилгын засварын материал		3,388,000.00	2,952,000.00
Хүнсний материал		5,173,460.00	3,096,080.00
Бусад хангамжийн материал		29,865,548.22	38,201,481.62
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>561,849,311.91</b>	<b>623,058,239.87</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		<b>5,143,985,157.46</b>	<b>5,090,390,928.13</b>
<b><u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u></b>	<b>7</b>	<b>5,143,985,157.46</b>	<b>5,090,390,928.13</b>
<b><u>Биет хөрөнгө</u></b>		<b>4,976,175,557.54</b>	<b>4,922,713,728.29</b>
Барилга, байгууламж		3,961,044,737.00	4,172,555,707.00
Хуримтлагдсан элэгдэл		-113,431,497.84	-179,448,910.08
Авто тээврийн хэрэгсэл		264,950,000.00	264,950,000.00
Хуримтлагдсан элэгдэл		-2,207,916.67	-28,702,916.71
Машин, тоног төхөөрөмж (компьютер)		536,168,311.00	568,314,069.00
Хуримтлагдсан элэгдэл		-142,135,332.19	-240,792,352.84
Тавилга, аж ахуйн эд хогшил		203,991,631.70	213,443,831.70
Хуримтлагдсан элэгдэл		-49,259,409.25	-83,936,901.76
Бусад үндсэн хөрөнгө		541,427,540.61	552,532,740.61
Хуримтлагдсан элэгдэл		-258,898,602.87	-350,997,634.68
Номын фонд		34,526,096.05	34,796,096.05
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>		<b>167,809,599.92</b>	<b>167,677,199.84</b>
Програм хангамж		662,000.00	662,000.00
Хасагдуулга		-132,400.08	-264,800.16
Бусад биет бус хөрөнгө		167,280,000.00	167,280,000.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>5,143,985,157.46</b>	<b>5,090,390,928.13</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>5,705,834,469.37</b>	<b>5,713,449,168.00</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			37,747,116.00
<b>Өглөг</b>	<b>9</b>		37,747,116.00
Ажиллагчидтай холбогдсон өглөг			
Бараа үйлчилгээний зардлын өглөг			37,747,116.00
<b><u>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u></b>			<b>37,747,116.00</b>
Урт хугацаат зээл			
<b><u>УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</u></b>	<b>10</b>		

<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>			
Засгийн газрын хувь оролцоо		5,705,834,469.37	5,675,702,052.00
Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан		1,187,537,602.87	1,187,537,602.87
Өмч: -Төрийн өмч		1,187,537,602.87	1,187,537,602.87
Хуримтлагдсан үр дүн		4,518,296,866.50	4,488,164,449.13
Өмнөх үеийн үр дүн		4,518,296,866.50	4,518,296,866.50
Тайлант үеийн үр дүн		-	-30,132,417.37
<b><u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</u></b>		<b>5,705,834,469.37</b>	<b>5,675,702,052.00</b>
<b><u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</u></b>		<b>5,705,834,469.37</b>	<b>5,713,449,168.00</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Тод руулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>2,854,260,300.00</b>	<b>3,309,536,300.00</b>
Улсын төвлөрсөн төсвөөс		2,512,270,300.00	2,988,476,300.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,512,270,300.00	2,988,476,300.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих		341,990,000.00	321,060,000.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		1,018,215,430.67	242,989,093.43
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,208,100.00	8,402,900.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		175,000.00	140,000.00
Өмчийн орлого-үндсэн хөрөнгө		976,020,905.87	228,728,095.03
Өмчийн орлого-бараа материал		36,811,424.80	5,718,098.40
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>3,872,475,730.67</b>	<b>3,552,525,393.43</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		<b>2,914,896,435.48</b>	<b>3,582,657,810.80</b>
<b><u>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u></b>	-	<b><u>1,969,654,815.13</u></b>	<b><u>2,515,290,841.64</u></b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>1,755,740,350.69</b>	<b>2,237,309,970.83</b>
Цалин		1,259,565,978.69	1,510,897,153.83
Цалингийн тусгай нэмэгдлүүд		496,174,372.00	726,412,817.00
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>		<b>213,914,464.44</b>	<b>277,980,870.81</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл		180,223,740.15	234,727,628.51
Эрүүл мэндийн даатгалын хураамж		33,690,724.29	43,253,242.30
<b><u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</u></b>		<b>945,241,620.35</b>	<b>1,067,366,969.16</b>
<b>Тогтмол зардал</b>		<b>290,099,525.44</b>	<b>348,357,739.62</b>

Гэрэл цахилгааны зардал		18,995,994.33	14,593,822.22
Түлш, халаалтын зардал		247,452,421.61	301,989,469.00
Цэвэр, бохир усны зардал		23,651,109.50	31,774,448.40
Хоол		164,606,875.00	218,226,580.00
Эм		592,261.40	671,600.00
Бусад бараа үйлчилгээний зардал		<b>655,142,094.91</b>	<b>719,009,229.54</b>
Бичиг хэргийн материал		30,844,700.00	32,835,050.00
Тээвэр, шатахууны зардал		-	1,230,000.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс		10,591,982.00	10,216,328.00
Бараа материал акталсны зардал		4,885,423.81	11,017,565.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		-	7,902,900.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс		21,703,257.37	21,577,528.44
Бараа үйлчилгээний бусад зардал		52,066,300.00	47,118,877.36
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		256,787,320.77	326,716,424.36
Төвлөрүүлэх шилжүүлэг		33,890,474.56	449,376.38
Урсгал засварын зардал		46,640,700.00	14,453,900.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		32,532,800.00	26,593,100.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>3</b>	<b>2,914,896,435.48</b>	<b>3,582,657,810.80</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>957,579,295.19</b>	<b>-30,132,417.37</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>		<b>(5,705,037.00)</b>	<b>-</b>
Үнэ төлбөргүй гарсан зардал		<b>(5,705,037.00)</b>	<b>-</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>-5,705,037.00</b>	<b>-</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>		<b>951,874,258.19</b>	<b>-30,132,417.37</b>
Хяналтын хувь оролцоонд хамаарах үр дүн			

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Үзүү-лэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	төгрөгөөр	
			Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2024. оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,187,537,602.87	483,805,300.52	4,518,296,866.50	5,705,834,469.37

Тайлант үеийн үр дүн			(37,563,397.98)	(37,563,397.98)
2024.. оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,187,537,602.87		4,518,296,866.50	5,705,834,469.37
Тайлант үеийн үр дүн			-30,132,417.37	-30,132,417.37
2025. оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,187,537,602.87	483,805,300.52	4,488,164,449.13	5,675,702,052.00

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

### Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>2,859,643,400.00</b>	<b>3,318,079,200.00</b>
Улсын төсвөөс	2,512,270,300.00	2,988,476,300.00
Орон нутгийн төсвөөс	341,990,000.00	321,060,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,208,100.00	8,402,900.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	140,000.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,859,643,400.00</b>	<b>3,318,079,200.00</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>1,969,654,815.13</b>	<b>2,515,290,841.64</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,755,740,350.69</b>	<b>2,237,309,970.83</b>
Цалин	1,259,565,978.69	1,510,897,153.83
Цалингийн тусгай нэмэгдлүүд	496,174,372.00	726,412,817.00
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>213,914,464.44</b>	<b>277,980,870.81</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	180,223,740.15	234,727,628.51
Эрүүл мэндийн даатгалын хураамж	33,690,724.29	43,253,242.30
<b>Бараа ,үйлчилгээний урсгал зардал</b>	<b>386,612,227.93</b>	<b>399,764,860.18</b>
<b>Тогтмол зардал</b>	<b>290,099,525.44</b>	<b>310,610,623.62</b>
Гэрэл цахилгааны зардал	18,995,994.33	14,593,822.22
Түлш, халаалтын зардал	247,452,421.61	264,242,353.00
Цэвэр, бохир усны зардал	23,651,109.50	31,774,448.40
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,208,100.00	7,902,900.00
Хоол	147,610,896.00	216,149,200.00
Бараа үйлчилгээний бусад зардал	107,241,500.00	81,538,129.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,108,257.37	35,508,154.80
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	20,020,200.00	21,624,000.00
Урсгал засварын зардал	18,000,000.00	10,000,000.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	32,532,800.00	26,593,100.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	33,890,474.56	449,376.38

<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>2,646,366,568.50</b>	<b>3,225,666,325.44</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>213,276,831.50</b>	<b>92,412,874.56</b>
<b>Хөрөнгийн орлого</b>		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Бусад хөрөнгийн борлуулалтын орлого		
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)</b>	<b>79,307,300.00</b>	<b>44,394,100.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	79,307,300.00	44,394,100.00
Хөрөнгийн бусад зардал		
гарсан зардлаа дансны нэгдсэн жагсаалтаас авах		
.....		
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)</b>	<b>-79,307,300.00</b>	<b>-44,394,100.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)</b>	<b>-79,307,300.00</b>	<b>-44,394,100.00</b>
Авсан зээл		
Төлсөн зээл		
<b>САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)</b>		
Валютын ханшийн зөрүү		
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)</b>	<b>133,969,531.50</b>	<b>48,018,774.56</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	353,014,975.59	486,984,507.09
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	486,984,507.09	535,003,281.65

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Хүснэгт 5. төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>3,821,352,200.00</b>	<b>3,318,079,200.00</b>	<b>-48,018,700.00</b>	<b>85.6</b>
Улсын төсвөөс	3,491,749,300.00	2,988,476,300.00	-48,018,700.00	98.4
Орон нутгийн төсвөөс	321,060,000.00	321,060,000.00	0	100
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	8,402,900.00	8,402,900.00	0	100
Туслах үйл ажиллагааны орлого	140,000.00	140,000.00	0	100
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,821,352,200.00</b>	<b>3,318,079,200.00</b>	<b>-48018700.00</b>	<b>85.6</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>3,005,694,800.00</b>	<b>2,515,290,841.64</b>	<b>490,403,958.36</b>	<b>83.6</b>

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,671,640,200.00	2,237,309,970.83	434,330,229.17	83.7
Цалин	1,709,312,200.00	1,510,897,153.83	198,415,046.17	88.4
Цалингийн тусгай нэмэгдлүүд	962,328,000.00	726,412,817.00	-454805341.00	75.4
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>334,054,600.00</b>	<b>277,980,870.81</b>	<b>-56,073,729.19</b>	<b>83.2</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	280,605,900.00	234,727,628.51	45,878,271.49	83.6
Эрүүл мэндийн даатгалын хураамж	53,448,700.00	43,253,242.30	-10,195,457.70	80.9
<b>Бараа ,үйлчилгээний урсгал зардал</b>	<b>504,597,400.00</b>	<b>443,709,583.80</b>	<b>60,887,816.20</b>	<b>87.9</b>
Тогтмол зардал	311,060,000.00	310,610,623.62	-449,376.38	99.9
Гэрэл цахилгааны зардал	20,000,000.00	14,593,822.22	-5,406,177.78	73
Түлш, халаалтын зардал	281,060,000.00	264,242,353.00	-16,817,647.00	94
Цэвэр, бохир усны зардал	10,000,000.00	31,774,448.40	21,774,448.40	317.7
<b>Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал</b>	<b>504,597,400.00</b>	<b>443,709,583.80</b>	<b>60,887,816.20</b>	<b>87.9</b>
Хоол	248,552,200.00	216,149,200.00	-32,403,000.00	87
Бусад бараа үйлчилгээний зардал	126,601,600.00	125,932,229.00	-669,371.00	99.5
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	21,624,000.00	21,624,000.00	0	100
Урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	0	100
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,902,900.00	7,902,900.00	0	100
Мэдээллийн технологийн зардал	63,323,600.00	35,508,154.80	-27,815,445.20	56.1
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	26,593,100.00	26,593,100.00	0	100
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>3,821,352,200.00</b>	<b>3,269,611,049.06</b>	<b>551,741,150.94</b>	<b>85.5</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		486,984,507.09		

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		535,003,281.65		
---	--	----------------	--	--

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 385.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 385.0 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- ✓ Бараа материалын тодруулга тайланд 385.0 мянган төгрөгийн урсгал засварын зардлыг буруу бүртгэснийг захирал, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрч залруулга хийсэн.

Аудитаар нийт 742,265.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 742, 265.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

#### 3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 3.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

#### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

##### 1.Илрүүлэлт:

Сургуулийн удирдлага нь шууд худалдан авалт хийхдээ үнийн судалгааг бүрэн хийгээгүйгээс 5 ширхэг зөөврийн компьютер, 1 ширхэг скайнерийг зах зээлийн үнээс 4,450.0 мянган төгрөгөөр өндөр үнэтэйгээр бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

##### Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө худалдан авахаас өмнөх үнийн судалгааг сайтар хийн баримтжуулах, зах зээлийн үнээс өндөр үнэтэй хөрөнгө олж бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоох;

#### Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

##### 2.Илрүүлэлт:

Тус сургуулийн дотоод хяналтын нэгж нь 2024-2025 оны хичээлийн жилд төлөвлөсөн 8 ажлаас 3 ажлыг бүрэн хэрэгжүүлсэн, хяналтаар илэрсэн алдаа зөрчлийг нэгтгэн дүгнээгүй, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар тодорхой ажил зохион байгуулж, тайлагнаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.7.3, 3.7.8 зэрэг заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын нэгжид төлөвлөсөн хяналт шалгалтыг бүрэн хийх, хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх, дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх үүргүүдийг өгч биелэлтийг тооцох;

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

## Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

### 3.Илрүүлэлт:

Эд хариуцагч нь 2025 оны 7-11 дугаар сарын бараа материалын тайланг хугацаанд нь гаргаагүй байна. Энэ нь тус сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөөгүй, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Эд хариуцагчид бараа материалын тайланг тус сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргаж хэвших үүргийг хүргүүлэн, үр дүнг хянах;

## Нийцлийн аудиттай холбоотой асуудал

### 4.Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд 737,815.4 мянган төгрөгийн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4-д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим системд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Хүснэгт 6. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалын тодруулга тайланд урсгал засварын зардлыг буруу бүртгэсэн	1	385.0			1	385.0	1	385.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>385.0</b>			<b>1</b>	<b>385.0</b>	<b>1</b>	<b>385.0</b>				

### Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Сургуулийн дотоод хяналтын нэгж хангалтгүй ажилласан	1	0.0					1	0.0
Эд хариуцагч нь 2025 оны зарим сарын бараа материалын тайланг хугацаанд нь гаргаагүй	1	0.0					1	0.0
Сургуулийн удирдлага нь 5 ширхэг зөөврийн компьютер, 1 ширхэг скайнерийг зах зээлийн үнээс өндөр үнэтэйгээр худалдан авсан;	1	4,450.0					1	4,450.0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>4,450.0</b>					<b>3</b>	<b>4,450.0</b>

**Хүснэгт 8. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг мэдээлээгүй	1	737,815.4					1	737,815.4
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>737,815.4</b>					<b>1</b>	<b>737,815.4</b>